



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/362

Мандалговь

Аймгийн Музейн үйл ажиллагаанд  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.10, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Музейн үүсэл хөгжлийн 70 жилийн түүхэн замналыг баримтжуулах оюуны бүтээл “Талын суурингийн Музейн түүх” номын хэвлэлтийн зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Ном хэвлүүлэх зардалд 2.000.000 (Хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191027